

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ

Л.Наранчимэг*

Хураангуй: Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны явц болон үр дүнг зохих үзүүлэлтийн системээр судлан, байгууллагын өнөөгийн болон хэтийн төлөв байдалд дүгнэлт өгөх, улмаар санхүүгийн үр дүнд нөлөөлсөн хүчин зүйл учир шалтгааныг тодорхойлох замаар бизнесийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх, шийдвэрийн гүйцэтгэлийг хянах санхүү эдийн засаг, удирдлагын арга хэрэгсэл бол санхүү эдийн засгийн шинжилгээ юм. Зах зээлийн нөхцөлд аливаа бизнесийн байгууллага оршин тогтнох эсэхийн баталгаа нь үйл ажиллагааны төдийгүй санхүүгийн байдлаас ихээхэн хамааралтай. Удирдлагын шийдвэрийн оновчлолыг хангахад чиглэсэн шийдвэр гаргалтын олон аргуудыг хэрэглэдэг. Үүнээс хамгийн түгээмэл нь нөхцөл байдлыг загварчлах явдал юм. Загвар нь асуудлыг тодорхой системд оруулж, эрэмбэ дарааллаар нь судлан танин мэдэх, шинжлэн судлах явдлыг хялбаршуулдаг давуу талтай юм.

Түлхүүр үг: Санхүүгийн үндсэн харьцаанууд, санхүүгийн үйл ажиллагааны сул тал

Оршил


Компанийн санхүүгийн үзүүлэлтүүд, тэр дундаа үйл ажиллагааны эцсийн үр дүнг бусад үзүүлэлтүүдтэй хэрхэн холбогдож буй хамаарлыг судалснаар компанийн санхүүгийн үр ашгийн үзүүлэлтүүд, түүнийг удирдахад шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлэх ихээхэн ач холбогдолтой билээ. Аливаа байгууллага санхүүгийн хувьд тогтвортой, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж амжилттай ажиллахын гол нөхцөл нь үзүүлэлтүүдийн өсөлт бууралтын ердийн шаардлагыг хангах төдийгүй тодорхой загварын дагуу үзүүлэлтүүдийн тодорхой динамик хамаарлыг баримтлах явдал байдаг. Хэрвээ тухайн загварын цогц нөхцлийг хангахгүйгээр аж ахуйн нэгж байгууллагын (ААНБ) үйл ажиллагаа зарим үзүүлэлтээр шаардлагатай үр дүнд хүрч байгаа нь амжилттай гэж тооцогдохгүй. Аж ахуйн нэгж байгууллага санхүүгийн хувьд тогтвортой, үйл ажиллагаа доголдолгүй жигд ажиллахын тулд Зураг 1-д харуулсан загварын

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) lombodorjnaraa@gmail.com

дагуу үзүүлэлтүүдийн динамик өсөлтийн тодорхой хамаарлыг баримтлах ёстой гэдгийг судлаачид санал болгосон байна.

Санхүүгийн үзүүлэлтүүдийг эрэмбэлэх нь

Зураг 1.



- Кал- Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа
- Кл- Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа
- Кп- Эргэлтийн харьцаа
- Коок-Үндсэн хөрөнгийн ачаалал
- Коа- Өөрийн хөрөнгийн ачаалал
- Кпп- Хүү төлөх чадвар
- Кнр- Ашигт ажиллагааны түвшин
- ROA-Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа
- ROE- Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа
- Ккз- Өглөгийн эргэц
- Ки- Авлагын эргэц
- Кз- Материаллаг нөөцийн эргэц
- Ккс-Эх үүсвэрийн квота
- Кд- Өр төлбөрийн харьцаа
- Кфр-Санхүүгийн хөшүүрэг

Эх сурвалж. А.С. Тонких. “Моделирование результативного управления финансами”. Москва 2009.

Дүрслэгдсэн загварыг аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэлтүүдийг “эрэмблэх” гэж нэрлэнэ. Загварт сум бүрийн чиглэл “>” байгаа нь тэнцвэр биш болохыг илэрхийлж байна. Тухайн загвар нь аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны нилээд гол үзүүлэлтүүд харилцан бие биенээсээ хамааран өөрчлөгдөж байгаа байдал ба чиглэлийг харуулдаг. Уг загварын нөхцлийг хангахгүй бол тухайн ААНБ-д санхүүгийн хувьд асуудал үүссэн болохыг харуулах ба загварын агуулга бүхий л салбарт хамааралтай юм. Загварт нийцэхгүй байгаа явдал их байхын хирээр асуудлын хэмжээ мэдэгдэхүйц их болдог²

Хүснэгт 1. Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

	Тэмдэглэгээ	Тооцох журам	Өсөлт/бууралт
Төлбөрийн чадварын үзүүлэлтүүд			
1.Эргэлтийн харьцаа	Кп	<u>Эргэлтийн хөрөнгө</u> БХӨ	Өсөлт

2 А.С. Тонких. “Моделирование результативного управления финансами”. Москва 2009.

2.Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө } 3/4}{\text{БХӨ}}$	Өсөлт
3.Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	$\frac{\text{Мөнгөн хөрөнгө} + \text{БХХО}}{\text{БХӨ}}$	Өсөлт
2.Үйл ажиллагааны идэвхжилийн үзүүлэлтүүд			
4.Материаллаг нөөцийн эргэц (хоногоор)	Кз	$\frac{\text{Материаллаг нөөц}}{\text{ББӨ}/360}$	Бууралт
5.Авлагын эргэц (хоногоор)	Ки	$\frac{\text{Авлага}}{\text{БО}/360}$	Бууралт
6. Өглөгийн эргэц (хоногоор)	Ккз	$\frac{\text{Өр төлбөр}}{\text{ББӨ}/360}$	Бууралт
7.Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	$\frac{\text{БО}}{\text{Өөрийн хөрөнгө}}$	Өсөлт
8. Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	$\frac{\text{БО}}{\text{Үндсэн хөрөнгө}}$	Өсөлт
3. Хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний үзүүлэлтүүд			
9.Эх үүсвэрийн квота харьцаа —	Ккс	$\frac{\text{УХӨ}}{\text{Хувь нийтлүүлсэн хөрөнгө}}$	Бууралт
10. Санхүүгийн хөшүүрэг	Кфр	$\frac{\text{Нийт өр төлбөр}}{\text{ХНХ} + \text{Хуримтлагдсан ашиг}}$	Бууралт
11. Өр төлбөрийн харьцаа	Кд	$\frac{\text{Нийт өр төлбөр}}{\text{Нийт хөрөнгө}}$	Бууралт
12. Хүү төлөх чадвар	Кпп	$\frac{\text{ХТТӨАшиг}}{\text{хүүгийн зардал}}$	Өсөлт
4.Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд			
13.Ашигт ажиллагааны түвшин	Кнр	$\frac{\text{Цэвэр ашиг}}{\text{БО}}$	Өсөлт
14.Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	$\frac{\text{Цэвэр ашиг}}{\text{Нийт хөрөнгө}}$	Өсөлт
15. Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	ROE	$\frac{\text{Цэвэр ашиг}}{\text{ХНХХөрөнгө}}$	Өсөлт

Эх сурвалж: А.Ф. Ионова, Н.Н.Селезнева “ Финансовый анализ” Москва 2010, 186-187 тал

Санхүүгийн үйл ажиллагааны “явцуу” дамжлагыг илрүүлэх тооцоолол

Дээрх загварын салаа мөчрийн нэг хэсэгт явцуу сул дамжлагыг хэрхэн илрүүлэхийг хийсвэр жишээгээр авч үзье. Таамаглаж буй a, b, c, d үзүүлэлтүүдийн нормативт эрэмбэ $a-b-c-d$ байна гэж үзье. Энэ нь динамик эгнээнд a үзүүлэлт суурь өмнөх үетэй харьцуулахад бусад үзүүлэлтүүдээс илүү хурдан өсөх ёстой болохыг харуулж байна. d –ийн өсөлт бусад өгөгдсөн үзүүлэлтүүдийн өсөлтөөс илүүгүй байх ёстой. Хэрвээ авч үзэж буй үзүүлэлтүүдийн бодит эрэмбэ санал болгож буйтай тохирч байвал санхүүгийн үйл ажиллагаанд хэлбэлзэл байхгүй, улмаар нэн тэргүүний өөрчлөлтийг шаардаж буй явцуу дамжлага мөн байхгүй гэсэн үг. Өгөгдсөн түвшинд хүрсэн үр дүнг хадгалах нь чухал юм.

Үзүүлэлтүүд	Нормативт эрэмбэ (a-b-c-d)	Гүйцэтгэлийн эрэмбэ (d-a-c-b)
a	1	2
b	2	4
c	3	3
d	4	1

Дараах тооцооллын дагуу эрэмбийн хазайлтыг тооцно.

Үүнд: $V_i = R_{in} - R_{if}$ (1)

- V_i – i үзүүлэлтийн нормативт ба жинхэнэ эрэмбийн зэргийн хазайлт
- R_{in} - нормативт эрэмбэд i – p үзүүлэлтийн зэрэг
- R_{if} - гүйцэтгэлийн эрэмбэд i – p үзүүлэлтийн зэрэг

Цаашид байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг эрэмбэлэх загварын бүх салаа мөчрийн үр дүнгийн шинжилгээгхийх шаардлагатай.

Үүний тулд Зураг 1 –д байгаа санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг эрэмбэлсэн загварыг эргэн авч үзье. График 12 салаа мөчрөөс тогтсон байна. Тухайлбал:

1. ROE → ROA → $K_{нр}$ → 1 → $K_{кз}$ → K_i → K_3
2. Кал → Кл → Кп → 1 → $K_{кз}$ → K_i → K_3
3. Коок → Коа → 1 → $K_{кз}$ → Кфр
4. Коок → Коа → 1 → $K_{кз}$ → K_i → K_3
5. Коок → Коа → 1 → Кд → Кфр
6. Кал → Кл → Кп → 1 → Кд → Кфр
7. Кал → Кл → Кп → 1 → $K_{кз}$ → Кфр
8. ROE → ROA → $K_{нр}$ → 1 → Кд → фр
9. ROE → ROA → $K_{нр}$ → 1 → $K_{кз}$ → Кфр
10. Кпп → 1 → Кд → Кфр
11. Кпп → 1 → $K_{кз}$ → Кфр
12. Кпп → 1 → $K_{кз}$ → K_i → K_3

Эдгээр эрэмбэд өсөлтийн нормын дараах харьцаа харгалзана:

$$1.h(ROE) > h(ROA) > h(K_{нр}) > 1 > h(K_{кз}) > h(K_i) > h(K_3)$$

$$2.h(K_{ал}) > h(K_{л}) > h(K_{п}) > 1 > h(K_{кз}) > h(K_{и}) > h(K_{з})$$

$$3.h(K_{оок}) > h(K_{оа}) > 1 > h(K_{кс}) > h(K_{фр})$$

Цаашид үйлдвэрийн үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэлтүүдийг эрэмбэлэх графикын 12 салаа мөчрөөр жинхэнэ үзүүлэлт нормативаас хэлбэлзэх байдлыг дээрх журмын дагуу тооцдог. Тэдгээрийн нийлбэрээс асуудалтай үзүүлэлтийг илрүүлэхийн тулд дараах томъёогоор дагуу эрэмбэлэх графикийн бүх салаа мөчрөөр үзүүлэлт бүрийн хэлбэлзлийн модулийн дундаж утгыг тооцно:

$$B_i^{cp} = \sum_{k=1}^n \frac{B_i}{m} \quad (2)$$

m- i-үзүүлэлт багтаж байгаа эталон эрэмбэлэх загварын салаа мөчрийн тоо
n- салаа мөчрийн дугаар.

Судалгааны хэсэг “XXX”ХК-ийн санхүүгийн үйл ажиллагааны сул хэсгийг илрүүлж арилгах тооцоолол, үр дүн

Хүснэгт 2 “XXX” компани санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд.

		Тэмдэглэгээ	2013	2014	2015	Өсөлт/ бууралт
1. Төлбөрийн чадварын үзүүлэлтүүд						
1	Эргэлтийн харьцаа	Кп	2,4991	3,6172	2,7646	>2
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	1,8744	2,7129	2,0735	>1
3	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	0,1063	1,8046	0,5982	>0.3
2. Үйл ажиллагааны идэвхжиллийн үзүүлэлтүүд						
4	Материаллаг нөөцийн эргэц	Кз	185,6755	103,1298	162,8532	<1
5	Авлагын эргэц	Ки	34,6938	0,8733	0,4912	<1
6	Өглөгийн эргэц	Ккз	53,2346	0,4229	6,3341	<1
7	Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	1,4334	1,6237	1,8257	>1
8	Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	9,7658	24,1789	8,1422	>1
	Эх үүсвэрийн квота харьцаа	Ккс	6,0422	6,0265	6,0265	<1
10	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	0,8363	0,5959	0,5703	<1

11	Өр төлбөрийн харьцаа	Кд	0,4554	0,3669	0,3629	<1
12	Хүү төлөх чадвар	Кпп	9,3010	181,7651	6,2775	>1
4. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд						
13	Ашигт ажиллагааны түвшин	Кнр	0,1184	0,1582	0,2000	>1
14	Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	0,1697	0,2569	0,3651	>1
15	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	ROE	8,9664	14,1782	26,6534	>1

Эх сурвалж: “XXX” компани санхүүгийн тайланг
үндэслэн судлаачийн тооцсоноор

Компани 2013 оны санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг эрэмбэлэх

Хүснэгт 3. Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 1-р эрэмбийн үзүүлэлтүүд

	Үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ	Нормативт эрэмбэ	Өсөлт	Гүйцэтгэлийн эрэмбэ	Эрэмбийн хэлбэлзэл	Модуль
1	ХНХ-ийн ашигт ажиллагааны түвшин	ROE	1	8,9664	4	-3	3
2	Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	2	0,1697	6	-4	4
3	Ашигт ажиллагааны түвшин	Кнр	3	0,1184	7	-4	4
4	1	1	4	1,0000	5	-1	1
5	Өглөгийн эргэц	Ккз	5	53,2346	2	3	3
6	Авлагын эргэц	Ки	6	34,6938	3	3	3
7	Материаллаг нөөцийн эргэц	Кз	7	162,6755	1	6	6

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 2-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	1	0,1063	7	-6	6
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	2	1,8744	5	-3	3
3	Эргэлтийн харьцаа	Кп	3	2,4991	4	-1	1
4	1	1	4	1,0000	6	-2	2
5	Өглөгийн эргэц	Ккз	5	53,2346	2	3	3
6	Авлагын эргэц	Ки	6	34,6938	3	3	3

7	Материаллаг нөөцийн эргэц	Кз	7	162,6755	1	6	6
---	---------------------------	----	---	----------	---	---	---

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 3-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	1	9,7658	1	0	0
2	Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	2	1,4334	3	-1	1
3	1	1	3	1,0000	4	-1	1
4	Эх үүсвэрийн квот ахарьцаа	Ккс	4	6,0422	2	2	2
5	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	5	0,8363	5	0	0

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 4-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	1	9,7658	4	-3	3
2	Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	2	1,4334	5	-3	3
3	1	1	3	1,0000	6	-3	3
4	Өглөгийн эргэц	Ккз	4	53,2346	2	2	2
5	Авлагын эргэц	Ки	5	34,6938	3	2	2
6	Материаллаг нөөцийн эргэц	Кз	6	185,6755	1	5	5

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 5-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	1	9,7658	1	0	0
2	Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	2	1,4334	2	0	0
3	1	1	3	1,0000	3	0	0
4	Өр төлбөрийн харьцаа	Кд	4	0,4554	5	-1	1
5	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	5	0,8363	4	1	1

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 6-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	1	0,1063	6	-5	5
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	2	1,8744	2	0	0
3	Эргэлтийн харьцаа	Кп	3	2,4991	1	2	2
4	1	1	4	1,0000	3	1	1
5	Өр төлбөрийн харьцаа	Кд	5	0,4554	5	0	0
6	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	6	0,8363	4	2	2

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 7-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	1	0,1063	6	-5	5
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	2	1,8744	3	-1	1
3	Эргэлтийн харьцаа	Кп	3	2,4991	2	1	1
4	1	1	4	1,0000	4	0	0
5	Эх үүсвэрийн квота харьцаа	Ккс	5	6,0422	1	4	4
6	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	6	0,8363	5	1	1

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 8-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	ХНХ-ийн ашигт ажиллагааны түвшин	ROE	1	8,9664	1	0	0
2	Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	2	0,1697	5	-3	3
3	Ашигт ажиллагааны түвшин	Кнр	3	0,1184	6	-3	3
4	1	1	4	1,0000	2	2	2
5	Өр төлбөрийн харьцаа	Кд	5	0,4554	4	1	1
6	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	6	0,8363	3	3	3

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 9-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	ХНХ-ийн ашигт ажиллагааны түвшин	ROE	1	8,9664	1	0	0
2	Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	2	0,1697	5	-3	3
3	Ашигт ажиллагааны түвшин	Кнр	3	0,1184	6	-3	3
4	1	1	4	1,0000	3	1	1
5	Эх үүсвэрийн квота харьцаа	Ккс	5	6,0422	2	3	3
6	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	6	0,8363	4	2	2

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 10-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Хүү төлөх чадвар	Кпп	1	9,3010	1	0	0
2	1	1	2	1,0000	2	0	0
3	Өр төлбөрийн харьцаа	Кд	3	0,4554	4	-1	1
4	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	4	0,8363	3	1	1

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 11-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Хүү төлөх чадвар	Кпп	1	9,3010	1	0	0
---	------------------	-----	---	--------	---	---	---

2	1	1	2	1,0000	3	-1	1
3	Эх үүсвэрийн квота харьцаа	Ккс	3	6,0422	2	1	1
4	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	4	0,8363	4	0	0

Санхүүгийн зэрэглэсэн хурдацын 12-р эрэмбийн үзүүлэлтүүд

1	Хүү төлөх чадвар	Кпп	1	9,3010	4	-3	3
2	1	1	2	1,0000	5	-3	3
3	Өглөгийн эргэц	Ккз	3	53,2346	2	1	1
4	Авлагын эргэц	Ки	4	34,6938	3	1	1
5	Материаллаг нөөцийн эргэц	Кз	5	185,6755	1	4	4

Цаашид үйлдвэрийн үйл ажиллагааны санхүүгийн үзүүлэлтүүдийг эрэмбэлэх графикын 12 салаа мөчрөөрөө жинхэнэ үзүүлэлт нормативаас хэлбэлзэх байдлыг дээрх журмын дагуу тооцдог. Тэдгээрийн нийлбэрээс асуудалтай үзүүлэлтийг илрүүлэхийн тулд дараах тооцооллын дагуу эрэмбэлэх графикын бүх салаа мөчрөөр үзүүлэлт бүрийн хэлбэлзлийн модулийн дундаж утгыг тооцно.

Хүснэгт 4. “XXX” компани санхүүгийн үйл ажиллагааны асуудалтай үзүүлэлтүүдийг илрүүлэх

	Үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ	Модулийн нийлбэр	Дундаж хэлбэлзэл	Асуудлын зэрэг
1	Эргэлтийн харьцаа	Кп	3	1	11
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Кл	4	1,3333	8
3	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Кал	16	5,3333	1
4	Материаллаг нөөцийн эргэц	Кз	21	5,25	2
5	Авлагын эргэц	Ки	9	2,25	6
6	Өглөгийн эргэц	Ккз	9	2,25	6
7	Өөрийн хөрөнгийн ачаалалт	Коа	4	1,3333	8
8	Үндсэн хөрөнгийн ачаалалт	Коок	3	1	11

9	Эх үүсвэрийн квота харьцаа	Ккс	10	2,5	5
10	Санхүүгийн хөшүүрэг	Кфр	10	1,25	10
11	Өр төлбөрийн харьцаа	Кд	3	0,75	15
12	Хүү төлөх чадвар	Кпп	3	1	11
13	Ашигт ажиллагааны түвшин	Кнр	10	3,3333	3
14	Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшин	ROA	10	3,3333	3
15	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	ROE	3	1	11

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

“Хэлбэлзлийн модулийн нийлбэр” баганад эрэмбэлэх нийт салаа мөчрөөр үзүүлэлт бүрийн хэлбэлзлийн модулийн нийлбэрийг тооцсон. Тухайлбал: 1-12-р эрэмбийн үзүүлэлтүүдийг тооцсон хүснэгтээс (хүснэгт 3) харахад:

Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагааны түвшингийн хэлбэлзлийн модулийн нийлбэр $3^* (3+0+0)$

Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшингийн хэлбэлзлийн модулийн нийлбэр $10^* (3+3+4)$

Ашигт ажиллагааны түвшингийн хэлбэлзлийн модулийн нийлбэр $10^* (3+3+4)$


“Дундаж хэлбэлзэл” гэсэн баганын тооцооллыг 3-р томъёоны дагуу тооцно. Тухайлбал: Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагааны түвшингийн хэлбэлзлийн модулийн нийлбэр 3-г уг үзүүлэлт багтаж байгаа эталон эрэмбэлэх загварын салаа мөчрийн тоо болох 3-т хувааж дундаж хэлбэлзэл 1^* гарч байна. Хөрөнгийн ашигт ажиллагааны түвшингийн дундаж хэлбэлзэл $3,333^* (10/3)$, ашигт ажиллагааны түвшингийн дундаж хэлбэлзэл $3,333 (10/3)$ гэж тус тус тооцлоо. Бусад үзүүлэлтүүдийн дундаж хэлбэлзэлийг дээрх аргачлалын дагуу тооцсон.

“Асуудлын зэрэг” баганын үзүүлэлт нь байдлыг засах шаардлагын зэргийг зааж байна. Тухайлбал: үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцааны $(5,333)$

дундаж хэлбэлзэл хамгийн их байгаа тул асуудалтай үзүүлэлт юм. Асуудалтай дараагийн үзүүлэлт нь материаллаг нөөцийн эргэц түүний асуудалд байдлын зэрэг 2 байна. Юуны өмнө эдгээр үзүүлэлтээр тодорхойлогдох дутагдлуудыг засахад удирдлагын зүгээс шийдвэр гаргах шаардлагатай байна.

Үр дүнд нь “явцуу” дамжлагыг арилгах шаардлагын дагуу дараах графиктай болно.

Зураг 2. “XXX” компани 2013 оны санхүүгийн удирдлагын асуудлыг арилгах шаардлагын график.




Загварын эхэнд хамгийн гол анхаарлыг шаардсан үзүүлэлтүүд тусгагдсан ба эцэс рүү шилжихийн хирээр үзүүлэлтүүдийн шахуу байдал буурах ба тэд харгалзах үйл ажиллагаанд ямар нэгэн эрс өөрчлөлтийг шаардахгүй.

Тус компанийн хувьд 2013 онд төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болох үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа (Kал), нийт хөрөнгийн ашигт ажиллагаа (ROA), хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт болох материаллаг нөөцийн эргэц (Kэз), өрийн харьцаа (Kкк) зэрэг үзүүлэлтүүд асуудлыг арилгах графикын эхэнд байна. Төлбөрийн чадварыг сайжруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулж материаллаг нөөцийн эргэц ихэсгэх зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.


Өмнөх аргачлалын дагуу 2014, 2015 онуудын тооцооллыг хийж, асуудлыг арилгах графикийг байгууллаа.

Зураг 3. “XXX” компани 2014 оны санхүүгийн удирдлагын асуудлыг арилгах шаардлагын график.




Тус компанийн хувьд 2014 онд төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болох үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа (Кал), нийт хөрөнгийн ашигт ажиллагаа (ROA), ашигт ажиллагааны түвшин(Кнр) хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт болох материаллаг нөөцийн эргэц (Кэ), өрийн харьцаа (Ккс) зэрэг үзүүлэлтүүд асуудлыг арилгах графикын эхэнд байна. Төлбөрийн чадвар өмнөх оноос бага зэрэг сайжирсан ч хангалттай түвшинд хүрч чадаагүй байна. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулжматериаллаг нөөцийн эргэцийг түргэгсгэх зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Зураг 4. “XXX” компанийн 2015 оны санхүүгийн удирдлагын асуудлыг арилгах шаардлагын график.



Тус компани 2015 оны хувьд төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болох үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа (Кал), нийт хөрөнгийн ашигт ажиллагаа (ROA), ашигт ажиллагааны түвшин(Кнр) хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт болох материаллаг нөөцийн эргэц (Кэ), өрийн харьцаа (Ккс) зэрэг үзүүлэлтүүд асуудлыг арилгах графикын эхэнд байна. Төлбөрийн чадвар өмнөх оноос бага зэрэг сайжирсан ч хангалттай түвшинд хүрч чадаагүй байгаа нь харагдаж байна. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулжматериаллаг нөөцийн эргэцийг түргэгсгэх зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна. 2013-2015 онуудын санхүүгийн удирдлагын асуудлыг арилгах графикийн эхэнд байгаа үзүүлэлтүүдийг харьцуулан графикаар илэрхийлбэл:



“XXX” компани санхүү сүүлийн 3 жилийн байдлаар төдийлөн өөрчлөгдөөгүй, үнэмлэхүй хөрөнгийн харьцаа 2015 онд 2013 оныхоос харьцангуй сайжирч, харин графикийн эхэнд байгаа бусад үзүүлэлт төдийлэн өөрчлөгдсөнгүй. Иймээс цаашид материаллаг нөөцийг эргэлтэнд оруулж, үйлдвэрлэлт борлуулалтыг түргэсгэж ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Дүгнэлт

Аливаа бүтээгдэхүүн үйлчилгээ, нийгмийн баялаг, орлого үр дүн нь аж ахуйн нэгж байгууллагын түвшинд бүтээгдэн, орлогын анхдагч болон дахин хуваарилалтаар нийгэм, хамт олон, ажилчид, хөрөнгө оруулагчдад хуваарилагддаг учраас, аж ахуйн нэгж байгууллагууд нь зах зээлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн болоод санхүүгийн тогтворжилтын суурь үндэс, анхдагч нэгж юм. Аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд жил бүрийн эцэст санхүүгийн тайлангийн шинжилгээний цогц мэдээллийг үндэслэн санхүүгийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэж дараа жилийнхээ төсөв, төлөвлөгөөг боловсруулдаг. Иймээс дээрх загвараар санхүүгийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэж сул талаа үнэн бодитой илрүүлж хамгийн их асуудалтай үзүүлэлтээсээ эхлэн үйл ажиллагаа төлөвлөх нь (жишээ болгон авсан XXX компани хувьд материаллаг нөөцийг эргэлтэнд оруулах, үйлдвэрлэлт борлуулалтыг түргэсгэх шаардлага байгааг судалгааны үр дүн харуулсан) тухайн байгууллага санхүүгийн хувьд тогтворжиж, хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Ашигласан материал

1. А.Ф. Ионова, Н.Н.Селезнева “ Финансовый анализ” Москва 2010, 186-187 тал
2. А.С. Тонких. “Моделирование результативного управления финансами”. Москва 2009.
3. Wahlen J.M, Baginski S.P, Bradshaw M. “Financial Reporting, Financial Statement Analysis and Valuation: A Strategic Perspective”, 2010
4. Монгол улсын Сангийн Яам. “Аж ахуйн нэгж байгууллагын Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”, 2015.12.18, №343
[www.unn.ru/pages/vestniki_journals/99990193_West_econ_finans_2005_1\(7\)/32.pdf](http://www.unn.ru/pages/vestniki_journals/99990193_West_econ_finans_2005_1(7)/32.pdf)
www.mof.gov.mn
<http://www.fin-izdat.ru/journal/analiz/>